

МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙДЫН ТУШААЛ

Тушаалд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.1 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Сангийн сайдын 2007 оны “Журам батлах тухай” 326 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтад дараахь нэмэлт, өөрчлөлтийг оруулсугай. Үүнд:

1. 1 дүгээр хавсралтын “Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-т:
 - а/ “2.ОРЛОГО” гэсэн бүлгийн “Татаас санхүүжилтийн орлогын бүртгэл” хэсгийн 2.7 (г)-д “Гадны хандивлагч байгууллагаас авсан зээлийн дүнг Улсын төсвөөс төлөхөөр бүртгэсэн үед Засгийн газрын шугамаар авч, ашиглаж буй зээлийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрийн тайлант онд хандивлагч орон, олон улсын байгууллагаас хүлээн авсан орлогыг дараахь байдлаар бүртгэнэ: Дт. Мөнгөн хөрөнгө-харилцах, Кт. Зээлийн хөрөнгийн эх үүсвэрээс олгосон санхүүжилтийн орлого” гэж;
 - б/ “УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР” гэсэн бүлгийн “Урт хугацаат зээлийн бүртгэл” хэсгийн 4.71-д Өмнөх онуудад хүлээн авсан орлогыг ур хугацаат өр төлбөр байдлаар бүртгэснийг УСНББОУС 3 “Тайлангийн үеийн цэвэр ашиг буюу алдагдал, суурь алдаа ба нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт” стандартын 59,60–р заалтын дагуу залруулахдаа дараахь байдлаар бүртгэнэ: г Дт. Урт хугацаат зээлийн өр, Кт. Өмнөх үеийн үр дүн “ гэсэн заалтыг тус тус нэмсүгэй.

Хоёр. Энэ тушаалыг 2011оны 12 дугаар сарын 1-нээс эхлэн төсөл, сангийн үйл ажиллагаанд мөрдөж ажиллахыг бүх төсвийн ерөнхийлөн захирагч нарт, энэ талаар мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлж хяналт тавьж ажиллахыг Төрийн сангийн газар /Х.Пүрэвсүрэн/, Нягтлан бодох бүртгэлийн бодлогын газар / С.Мягмардаш /-д тус тус үүрэг болгосугай.

САНГИЙН САЙД

С.БАЯРЦОГТ